



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/602

Булган сум

**Гүйцэтгэгчид гэрээ байгуулах
эрх олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн хуралдааны Х/74 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан “Биеийн тамирын заалны барилга (Могод сум)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр шалгарсан “Эко энерги ресурс” ХХК-тай 1 225 492 053 (нэг тэрбум хоёр зуун хорин таван сая дөрвөн зуун ерэн хоёр мянга тавин гурав) төгрөгөөр гэрээ байгуулж, холбогдох хууль, тогтоомж, гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т үүрэг болгосугай.

2.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандартын дагуу гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Эко энерги ресурс” ХХК-ийн захирал (Б.Пүрэвжамц)-д даалгасугай.

3.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй


ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



6325010818

Аймгийн Засаг даргын 2025 оны
09 дугаар сарын 19-ны өдрийн
А/602 дугаар захирамжийн авсралт



№	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадлашгүй ажил	20 880 223	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	20 880 223	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	10 440 112	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	23 000 000	Б.Ариунболд
5	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.2 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна	Б.Ариунболд
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн